



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

“Эрүүл иргэн-Эко хөгжил” спорт
өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.4.5, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ - ын дүрмийн 4.10.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ - ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Эрүүл иргэн - Эко хөгжил” спорт өдөрлөгийг 2020 оны 09 дүгээр сарын 12-26-ны өдрүүдэд Хүй долоон худагт зохион байгуулсугай.


2. “Эрүүл иргэн - Эко хөгжил” спорт өдөрлөгийн арга хэмжээг байгуулахад шаардагдах 13 804 000 /Арван гурван сая найман зуун дөрвөн мянга/ төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Г.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.

3. “Эрүүл иргэн - Эко хөгжил” спорт өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, удирдамж, хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар, ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, үйл ажиллагааны зардлыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Спорт өдөрлөгийг удирдамжийн дагуу зохион байгуулахыг Ахлах мэргэжилтэн /М.Хоролсүрэн/-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан гаргаж ажиллахыг Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /З.Зулгэрэл/-д үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЦОГТГЭРЭЛ

215030368

Монгол наадам цогцолбор ӨНӨТҮГ-ын
даргын 2020 оны 09 сарын 03-ны өдрийн
1/26 тоот тушаалын 1 хавсралт



**“ЭРҮҮЛ ИРГЭН-ЭКО ХӨГЖИЛ” СПОРТ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:

Ахлах мэргэжилтэн /М.Хоролсүрэн/

Гишүүд:

Нягтлан бодогч: /Г.Баярмаа/
Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн /Х.Чанцалдулам/
Ашиглалтын инженер /П.Анхбаяр/
Хөгжмийн техникч /Б.Баттулга/
Мастер /Ж.Баяндаваа/

Нарийн бичгийн дарга:

Хууль, хүний нөөц хариуцсан
мэргэжилтэн /З.Зулгэрэл/

Монгол наадам цогцолбор ӨНӨТҮГ-ын
даргын 2020 оны 09 сарын 23-ны өдрийн
4/26 тоот тушаалын 2 хавсралт

“ЭРҮҮЛ ИРГЭН-ЭКО ХӨГЖИЛ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР

2020.08.20

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2 заалтын Хүй долоон худаг дахь “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв болгох ажлын хүрээнд мөн нийслэлийн иргэд, хүүхэд залуусын амралт, чөлөөт цагийг эрүүл цэнгэг агаарт зөв боловсон өнгөрүүлэх, спортоор дамжуулан бие бялдар, зан төлөвшилтийн өв тэгш хүмүүжлийг олгох, Монгол ахуй соёлоо сурталчлах, эко тээврийн хэрэгсэл буюу унадаг дугуйг энгийн хэрэглээнд нэвтрүүлэх, нийтэд сурталчлах, дугуйн зам, маршрутыг нэмэгдүүлэх зэрэг нь тус арга хэмжээний үндсэн зорилгоо болгон ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлж зохион байгуулснаар Нийслэлийн иргэд, гадаад дотоодын жуулчид, залуу гэр бүл, хүүхэд залуусын чөлөөт цагийг эрүүл цэнгэг агаарт зөв боловсон өнгөрүүлэх аялал, амралт, зугаалгын тав тухтай орчинг бий болгож, аялал жуулчлалын шинэ маршрут, шинэ бүтээгдэхүүн бий болгон, нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хүүхэд залууст спортоор зөв хүмүүжил олгож эрүүл иргэн болгон төлөвшүүлэх үйл хэрэгт хувь нэмэр оруулах юм.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж спортоор хичээллэх сонирхол бүхий иргэд, хүүхэд залуус, тамирчдыг дугуйн марафон, сонирхогчдын марафон, 3х3 сагсан бөмбөгийн бооцоот тэмцээнд өргөнөөр оролцохыг урьж байна.

ГУРАВ. БАЙРШИЛ, ХУГАЦАА

“Эрүүл иргэн- Эко хөгжил” хөтөлбөрийн хүрээн дэх аялал зугаалга арга хэмжээ нь “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Хүй долоо худагт байрлах үйлчилгээний болон морь барианы талбайд 2020 оны 09 сарын 12-26-нд болно.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Зохион байгуулагч: “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ

Хамтран оролцогч байгууллагууд: Монголын хөнгөн атлетикийн холбоо

Монголын Дугуйн Холбоо, TLG – 13 ТББ.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Эрүүл иргэн-Эко хөгжил” хөтөлбөрийн хүрээн дэх аялал амралт зугаалга арга хэмжээ нь нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хүүхэд залууст спортоор зөв хүмүүжил олгож тэдний чөлөөт цагаа зөв боловсон ашиглаж сургахад чиглэгдэх ба энэхүү үйл ажиллагааны хүрээнд “Хүй долоо худаг”-т 9 дугаар сарын 12-26-ны өдрүүдэд

- Нээлтийн ажиллагаа
- Урлагийн номер
- 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн
- Уулын дугуйн уралдаан
- Сонирхогчдын марафон
- Явган аялал
- Хаалтын арга хэмжээ

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэмцээний төрөл бүрд эхний гурван байр шалгаруулж медаль мөнгөн шагналаар шагнана. Үүнд:

3х3 сагсан бөмбөгийн тэмцээн

Эрэгтэй, эмэгтэй насны ангилал бүрд:

НЭГДҮГЭЭР БАЙР	Алтан медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ХОЁРДУГААР БАЙР	Мөнгөн медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ГУРАВДУГААР БАЙР	Хүрэл медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл

Уулын дугуйн тэмцээн:

НЭГДҮГЭЭР БАЙР	Алтан медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ХОЁРДУГААР БАЙР	Мөнгөн медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ГУРАВДУГААР БАЙР	Хүрэл медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл

Сонирхогчдын марафон тэмцээн:

НЭГДҮГЭЭР БАЙР	Алтан медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ХОЁРДУГААР БАЙР	Мөнгөн медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл
ГУРАВДУГААР БАЙР	Хүрэл медаль, Мөнгөн шагнал, өргөмжлөл

ДОЛОО. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

1. 3х3 сагсан бөмбөгийн тэмцээний бүртгэл 2020 оны 09-р сарын 07-аас 09-р сарын 11-ний өдрүүдэд “ Монгол наадам цогцолбор ” ОНӨТҮГ-ын төв байранд ажлын цагаар бүртгэнэ.

2. Тэмцээнд бүртгүүлэхдээ багийн мэдүүлэг, багийн гишүүдийн 2 хувь цээж зураг, иргэний үнэмлэх эсвэл төрсний гэрчилгээний хуулбарын хамт бүртгүүлнэ.

НАЙМ . ТЭМЦЭЭНД МӨРДӨХ ЖУРАМ

1. 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн 18-25 нас (эрэгтэй , эмэгтэй), 25-35 нас (эрэгтэй, эмэгтэй), 35-аас (эрэгтэй) дээш насны ангиллаар явагдана.

2. 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд оролцох тамирчид хувцас жигдрэлт жигд байх .
3. Тамирчид тэмцээн эхлэхээс 1 цагийн өмнө тэмцээний талбайд ирсэн байх .

ЕС . ХӨТӨЛБӨР

Нэг дэх өдөр /2020.09.12/

Нээлтийн хөтөлбөр

- 11:00-11:05 Фанфар эгшиглэнэ. "ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ" арга хэмжээний нээлтэд уригдан ирсэн зочид, төлөөлөгчдийг танилцуулан тайзнаа урих
- 11:05-11:10 "ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ " арга хэмжээг нээж "МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР " ОНӨТҮГ-ын дарга Ц.Цогтгэрэл үг хэлнэ.
- 11:10-11:20 Зочид үг хэлнэ
- 11:20-11:25 Хүндэтгэлийн зураг авалт
- 11:20-11:50 Урлагийн номер
- 12:00-14:00 Бартаат замын дугуйн марафон (МНЦ - ын морь барианы талбайд)

Хоёр дахь өдөр /2020.09.19/

- 10:00-15:00 3х3 сонирхогчдын сагсан бөмбөгийн тэмцээн (МНЦ-ын сагсан бөмбөгийн талбайд)
- 12:00-14:00 Уулын дугуй тэмцээн (МНЦ-ын А,Б зам дагуу)
- 16:00-17:00 Хаалтын ажиллагаа, шагнал гардуулах ёслол (МНЦ-ын үйлчилгээний талбайн төвд зассан тайзанд)

Гурав дахь өдөр /2020.09.26/

- 12:00-17:00 Явган аялал, сонирхогчдын марафон

АРАВ. ХОЛБОО БАРИХ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Батмөнхийн гудамж, Велокс төв 602 тоот
Утас: 88050008, 7000 0695

Монгол наадам цогцолбор ӨНӨТҮГ-ын
даргын 2020 оны 09 сарын 03-ны өдрийн
А/26 тоот тушаалын 3 хавсралт

“ЭРҮҮЛ ИРГЭН-ЭКО ХӨГЖИЛ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР

2020.08.20

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.2 заалтын Хүй долоон худаг дахь “Монгол наадам цогцолбор” ӨНӨТҮГ-т үндэсний спортыг хөгжүүлэх, төрөлжсөн аялал жуулчлал, бизнес, соёлын төв болгох ажлын хүрээнд мөн нийслэлийн иргэд, хүүхэд залуусын амралт, чөлөөт цагийг эрүүл цэнгэг агаарт зөв боловсон өнгөрүүлэх, спортоор дамжуулан бие бялдар, зан төлөвшилтийн өв тэгш хүмүүжлийг олгох, Монгол ахуй соёлоо сурталчлах, эко тээврийн хэрэгсэл буюу унадаг дугуйг энгийн хэрэглээнд нэвтрүүлэх, нийтэд сурталчлах, дугуйн зам, маршрутыг нэмэгдүүлэх зэрэг нь тус арга хэмжээний үндсэн зорилгоо болгон ажиллаж байна.

Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлж зохион байгуулснаар Нийслэлийн иргэд, гадаад дотоодын жуулчид, залуу гэр бүл, хүүхэд залуусын чөлөөт цагийг эрүүл цэнгэг агаарт зөв боловсон өнгөрүүлэх аялал, амралт, зугаалгын тав тухтай орчинг бий болгож, аялал жуулчлалын шинэ маршрут, шинэ бүтээгдэхүүн бий болгон, нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хүүхэд залууст спортоор зөв хүмүүжил олгож эрүүл иргэн болгон төлөвшүүлэх үйл хэрэгт хувь нэмэр оруулах юм.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөж спортоор хичээллэх сонирхол бүхий иргэд, хүүхэд залуус, тамирчдыг дугуйн марафон, сонирхогчдын марафон, 3х3 сагсан бөмбөгийн бооцоот тэмцээнд өргөнөөр оролцохыг урьж байна.

ГУРАВ. БАЙРШИЛ, ХУГАЦАА

“Эрүүл иргэн- Эко хөгжил” хөтөлбөрийн хүрэн дэх аялал зугаалга арга хэмжээ нь “Монгол наадам цогцолбор” ӨНӨТҮГ-ын Хүй долоо худагт байрлах үйлчилгээний болон морь барианы талбайд 2020 оны 09 сарын 12-26-нд болно.

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Зохион байгуулагч: “Монгол наадам цогцолбор” ӨНӨТҮГ

Хамтран оролцогч байгууллагууд: Монголын хөнгөн атлетикийн холбоо

Монголын Дугуйн Холбоо, TLG – 13 ТББ.

Монгол наадам цогцолбор ӨНӨТҮГ-ын
даргын 2020 оны 09 сарын 03 -ны өдрийн
1/26 тоот тушаалын 4 хавсралт


“ЭРҮҮЛ ИРГЭН-ЭКО ХӨГЖИЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны 08-р сарын 20

Д/д	Ажлын нэр	Бэлэн болох хугацаа	Хариуцах хэлтэс, ажилтан	Тайлбар
1	“Эрүүл иргэн-Эко хөгжил” арга хэмжээний удирдамж, хөтөлбөр боловсруулж батлуулах	09.07-09.08	М.Хоролсүрэн	Арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэж, товч тодорхой бэлтгэх
2	Албан байгууллагуудад хамтран ажиллах санал хүргүүлэх	09.08-09.09	Маркетингийн алба	Хамтран ажиллах Монголын дугуйн холбоо, сагсан бөмбөгийн холбоо, их дээд сургуулиуд, бусад албан байгууллагууд
3	Арга хэмжээний тайз, лед дэлгэц, хөгжим, аппаратур угсралт	09.11	Маркетинг, Тохижилт үйлчилгээний алба	Тайз хэмжээг тохируулан угсрах
4	Тайзны хулдаасны эх бэлтгэл, хэвлэлт	09.01-09.10	З.Зулгэрэл Х.Кадирбек	Чанарын өндөр түвшинд хийлгэх
5	Нээлт, хаалтын арга хэмжээний хөтөлбөрийг бэлтгэх	09.07-09.10	Маркетингийн алба	Арга хэмжээний онцлогийг тусгасан хөтөлбөр гаргах
6	Дугуйн холбооноос явагдах тэмцээний бэлтгэл ажлыг хангах	09.10-09.11	Маркетинг, Тохижилт үйлчилгээний алба, МДХ	Дугуйн тэмцээний зам бэлдэнэ.
10	3х3 сагсан бөмбөгийн бооцоот тэмцээний бэлтгэл ажлыг хангах	09.17-09.18	Маркетингийн алба, Тохижилт үйлчилгээний алба	Сагсан бөмбөгийн талбай, сандал, хөгжим хэрэгсэл бэлтгэх
11	Арга хэмжээний үед дэлгэцэн дээр явах шторк	09.01-09.10	Х.Кадирбек Б.Баттулга	Тэмцээний утга агуулгыг харуулсан байх
12	Арга хэмжээний талбайн тохижилт, үйлчилгээг хангах	09.09-09.11	Санхүү, тохижилт, үйлчилгээний алба	Амрагчид, болон тамирчдын тав тухыг хангаж ажиллах
13	Хоол, хүнсний үйлчилгээ явуулах	09.11-09.26	Санхүү, тохижилт, үйлчилгээний алба	Тамирчдын тав тухыг хангаж ажиллах

14	Амралтын өдрөөр ажиллах ажилчдын хоолыг бэлтгэх	09.14-09.17	Санхүү, тохижилт, үйлчилгээний алба	
15	Арга хэмжээний тайлан гаргах	09.28-09.30	3.Зулгэрэл	

Монгол наадам цогцолбор ӨНӨТҮГ-ын
даргын 2020 оны 09 сарын 03 -ны өдрийн
А/26 тоот тушаалын 5 хавсралт



ЭРҮҮЛ ИРГЭН ЭКО ХӨГЖИЛ СПОРТ ӨДӨРЛӨГИЙН ТӨСӨВ

Д/д	Ажлын нэр	Дэлгэрэнгүй	Төсөв
1	Нээлт хаалтын арга хэмжээний зардал	Өөрсдийн тайз, дэлгэц, хөгжим хэрэгсэл гарна.	0
2	Талбайн тохижилтын зардал	Хүй долоо худагт тэмцээний талбай бэлдэх, 00 ажиллуулах ашиглалтын зардал	2 936 000
3	Бэлтгэл ажлын зардал	3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, уулын дугуйн уралдаан, сонирхогчдын марафон арга хэмжээний зохион байгуулалтын зардал	4 980 250
4	Шагнал урамшуулал зохион байгуулалтын зардал	3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, уулын дугуйн уралдаан, сонирхогчдын марафон уралдааны шагналын зардал	4 962 630
5	Ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	"Ковид-19" халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх санамж, талбай орчмын ариутгал, халдваргүйжүүлэлт, асуумж бүртгэл	925 120
НИЙТ ЗАРДАЛ			13 804 000